

БАРИЛГЫН НОРМАТИВ БАРИМТ БИЧГИЙН ТОГТОЛЦОО
МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН НОРМ БА ДҮРЭМ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ЗАСВАР,
АШИГЛАЛТЫН ХУГАЦААНЫ ЖИШИГ НОРМ

БНбД 13-04-03

Улаанбаатар хот 2003 он

БАРИЛГЫН НОРМАТИВ БАРИМТ БИЧГИЙН ТОГТОЛЦОО
МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН НОРМ БАДҮРЭМ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ЗАСВАР,
АШИГЛАЛТЫН ХУГАЦААНЫ ЖИШИГ НОРМ

БНбД 13-04-03

МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ЯАМ

Улаанбаатар хот 2003 он

1.Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газарт боловсруулав.

2.Дэд бүтцийн сайдын 2003 оны ... дугаар сарын -ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

3.Энэхүү норм, дүрмийг "Барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээний ашиглалтын үлгэрчилсэн дүрэм" (БНБД 1.06.06-95)-ийн оронд мөрдөнө.

Боловсруулсан:

А.Цэвэлмаа /Монгол Улсын мэргэшсэн инженер, магистр/

Хянан тохиолдуулсан:

Ж.Гэрэлхүү/МонголУлсынЗөвлөхинженер.професор/

Т.Норовжав /Монгол Улсын зөвлөх инженер -эдийн засагч/

Энэхүү нормативийн баримт бичгийг Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газар (Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг)-ын зөвшөөрөлгүйгээр бүрэн болон хэсэгчлэн/;

хувилах, олшруулах, тараахыг хориглоно.

МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН НОРМ БАДҮРЭМ
БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ЗАСВАР,
АШИГЛАЛТЫН ХУГАЦААНЫ ЖИШИГ НОРМ
ADVISTORY NORM FOR EXPLOITATION PERIODS AND MAINTENANSE SCHEDULES OF
BUILDINGS AND TECHNICAL SERVICES

2003 оны.....дугаар сарын..... -ны
өдрөөс эхлэн мөрдөнө.

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү норм нь өмчийн хэлбэрийг үл харгалзан орон сууцны барилга, олон нийт, соёл ахуйн зориулалтай объектуудын (цаашид барилга ба объект гэнэ) сэргээн засварлалт болон засвар, техникийн үйлчилгээний ажлын тогтолцооны дараалал ба бүрэлдэхүүнийг тогтооно.

Энэ норм нь олон нийт, соёл ахуйн зориулалтай барилга байгууламжийн тусгай технологийн тоног төхөөрөмжид хамаарахгүй.

1.2.Энэ нормыг барилгын техникийн үйлчилгээ, урсгал болон их засвар, сэргээн засварлалт хийх бүх байгууллага, аж ахуйн нэгжүүд заавал мөрдөнө.

1.3.Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдсан инженерийн хийцтэй барилга, байгууламжийн ашиглалтын явцад техникийн үзлэг, шалгалт явуулах, сэргээн засварлалт, засвар үйлчилгээ хийх болон тэдгээрийн үндсэн бүтээцийн шийдлээс хамааруулан ашиглалтын хугацааг тодорхойлоход энэхүү жишиг нормыг мөрдлөг болгоно.

1.4.Тухайн барилга, байгууламжийн өвөрмөц чанар, байгаль-цаг уурын нөхцөл болон ашиглалтын онцлогийг тусгасан барилга ба объектийн сэргээн засварлалт болон засвар, техникийн үйлчилгээний норм ба дүрмийг тухайн салбарын нормоор зохицуулж болно.

**Хоёр.Барилга ба объектийн сэргээн засварлалт болон
засвар, техникийн үйлчилгээний тогтолцоо**

2.1.Барилга, байгууламжийн сэргээн засварлалт болон засвар, техникийн үйлчилгээний тогтолцоо нь барилга, байгууламжийг хугацаанаасаа өмнө элэгдэж хуучрахаас хамгаалахад чиглэгдсэн өөр хоорондоо нягт холбоотой цогц зохион байгуулалтын ба техникийн үйл ажиллагааг агуулна. Энэ тогтолцоо нь материал, хөдөлмөр, санхүүгийн нөөц, түүнчлэн зайлшгүй хэрэгцээтэй норматив, техникийн баримт бичгийг хамарна.

2.2.Сэргээн засварлалт болон засвар, техникийн үйлчилгээний тогтолцоо нь барилга ба объектийг зориулалтаар нь, бүх хугацааных туршид ашиглах хэвийн үйл ажиллагааг хангаж байвал зохино.

2.3.Энэ нормд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.3.1."Барилгын бүрдэл хэсэг" гэж барилга байгууламжид тодорхой үүрэг гүйцэтгэж байгаа бүтээц эдлэл ба тоног хэрэгсэлийг;

2.3.2."Барилгын бүрдэл хэсгийн бүрэн бус байдал" гэж ашиглалтад тавигдсан шаардлагуудын аль нэг нь зөрчигдөж байгаа, бүрдэл хэсгийн байдлыг;

2.3.3."Барилгын бүрдэл хэсгийн гэмтэл" гэж гадны нөлөөллөөр барилгын бүрдэл хэсэг буюу түүний аль нэг эд ангид үүссэн бүрэн бус байдал (эвдрэл)-ыг;

2.3.4."Барилгын бүрдэл хэсгийн согог" гэж барилгын бүрдэл хэсгийг барьж байгуулах үед БНБД, техникийн нөхцлийг зөрчнөөс болж үүссэн бүрэн бус байдлыг;

2.3.5."Барилга ашиглалтын үзүүлэлтүүд" гэж барилга ашиглалтын чанарын нөхцөл болсон эдийн засаг ба гоо зүй, ариун цэвэр - эрүүл ахуй, эзэлхүүн төлөвлөлт, техникийн

шинж байдлуудын нийлмэл цогцыг;

2.3.6."Барилгын техникийн үйлчилгээ" гэж бүрдэл хэсгийн бүрэн бүтэн байдал ба түүнд тавигдсан шаардлагууд, түүнчлэн барилгын техникийн тоног хэрэгслийн ажиллах горимыг хангахад чиглэгдсэн цогц ажлыг;

2.3.7."Барилгын засвар" гэж барилгын техник эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг хөндөлгүйгээр физик ба моралийн элэгдлийг арилгахаар хийгддэг техник зохион байгуулалтын арга хэмжээ болон барилгын ажлын цогцыг;

2.3.8."Барилга байгууламжийн урсгал засвар" гэж барилга, байгууламжийн хийц хэсэг, инженерийн тоног төхөөрөмжийн элэгдлийг бууруулан хэвийн ажиллагааг хангах зорилгоор анхны болон дараагийн их засварын хооронд хийх барилгын засварыг;

2.3.9."Барилга байгууламжийн их засвар" гэж шаардлагатай үед барилгын бүтээцийн бүрдэл хэсэг ба инженерийн тоног төхөөрөмжийг солих, засаж сэлбэх, мөн түүнчлэн ашиглалтын байдлыг сайжруулах зорилгоор хийгддэг барилгын засварыг;

2.3.10."Барилга (бүрдэл хэсэг) -ын физик элэгдэл" гэж барилга (бүрдэл хэсэг)-ын техникийн болон түүнтэй холбоотой бусад ашиглалтын үзүүлэлтийн тодорхой хугацаан дахь бууралт, доройтолт (муудалт)-ын хэм хэмжээг илэрхийлэх хэмжигдэхүүнийг;

2.3.11."Барилгын моралийн элэгдэл (хоцрогдол)" гэж орчин үеийн амьдрал ахуйн түвшинг хангах шаардлагад тохирсон чанар, ажлын хэм хэмжээ, амьдрах нохцлийг тодорхойлж буй үндсэн өгөгдөхүүнд тохирохгүй хэмжээг илэрхийлэх хэмжигдэхүүнийг;

2.3.12."Барилгын сэргээн засварлалт" гэж үйлчлэх орон зайг ихэсгэх, үйлчилгээний чанар, амьдрах нөхцлийг сайжруулах зорилгоор техник эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд (барилгын нийт талбай, барилга байгуулалтын эзлэхүүн, сууцны талбай ба тоо, мөн барилгын хүч чадал, нэвтрүүлэх чадвар, зориулалт)-ийг өөрчлөхтэй холбогдсон техник-зохион байгуулалтын арга хэмжээ болон барилгын ажлын цогцыг;

2.3.13."Барилга байгууламжийн үзлэг" гэж барилга, байгууламжид урсгал ба их засвар, түүнчлэн шинэчлэл, өргөтгөл хийх нөхцлийг тодорхойлох зорилгоор барилгын бүрдэл хэсэгт үзлэг, судалгаа явуулж, үр дүнгээр нь дүгнэлт гаргах үйл явцыг;

2.4.Барилга, байгууламж болон түүний үндсэн бүтээцэд хийх засвар үйлчилгээний хугацааг, тухайн барилгын техникийн үзүүлэлтийг үндэслэн тодорхойлно. Барилга, байгууламжийн ашиглалтын явцад хийх засварын ажлын хугацааг хүснэгт 1-т заасны дагуу зөвлөмжийн чанартай мөрдөнө.

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ҮР АШИГТАЙ АШИГЛАЛТЫН
ХУГАЦААНЫ ХАМГИЙН БАГА ҮРГЭЛЖЛЭЛ**

Инженерийн хийцтэй барилга, байгууламжийн төрөл /үндсэн бүтээцийн материалаар/	Үр ашигтай ашиглалтын хугацаа, жилээр	
	Урсгал засвар хийх хүртэлх	Их засвар хийх хүртэлх
1	2	3
Хэвийн нөхцөлд ашиглах угсармал том хавтгаалжин, гулдмай, байгалийн чулуу ба тоосгон ханатай, төмөр бетон хучилттай барилга, байгууламжууд (орон сууцны барилга болон тэдгээртэй адилтгах температур ба чийгшилтийн горим бүхий орон байр)	3-5	15-20
Зохистой нөхцөлд ашиглах угсармал том хавтгаалжин, гулдмай, байгалийн чулуу ба тоосгон ханатай, төмөр бетон хучилттай тогтмол температур ба чийгшилтийн горим бүхий барилга, байгууламжууд (музей, архив, номын сан г.м)	3-5	20-25
Хүнд нөхцөлд ашиглах угсармал том хавтгаалж, гулдмай, байгалийн чулуу ба тоосгон ханатай, төмөр бетон хучилттай (орон сууцны барилга болон тэдгээртэй адилтгах температур ба чийгшилтийн горим бүхий орон байр) температурын үлэмж их хэлбэлзэлтэй, агаарын орчны бохирдолттой, үлэмж чийгтэй барилга, байгууламжууд (саун, нийтийн халуун усны болон угаалгын газар, бассейн, рашаан ба шавар эмчилгээний газрууд г.м), түүнчлэн задгай байгууламжууд (биеийн тамирын талбай, цэнгэлдэх хүрээлэн г.м)	2-3	10-15
Хэвийн нөхцөлд ашиглах тоосго ба байгалийн чулуун ханатай, модон хучилттай; модон болон бусад материалан ханатай (орон сууцны барилга болон тэдгээртэй адилтгах температур ба чийгшилтийн горим бүхий орон байр)	2-3	10-15
Зохистой нөхцөлд ашиглах тоосго ба байгалийн чулуун ханатай, модон хучилттай; модон болон бусад материалан ханатай, тогтмол температур ба чийгшилтийн горим бүхий барилга, байгууламжууд (музей, архив, номын сан г.м)	2-3	15-20
Хүнд нөхцөлд ашиглах тоосго ба байгалийн чулуун ханатай, модон хучилттай; модон болон бусад материалан ханатай, хэмийн үлэмж их хэлбэлзэлтэй, агаарын орчны бохирдолттой, үлэмж чийгтэй барилга, байгууламжууд (саун, нийтийн халуун усны болон угаалгын газар, бассейн, рашаан ба шавар эмчилгээний газрууд г.м) түүнчлэн задгай байгууламжууд (биеийн тамирын талбай, цэнгэлдэх хүрээлэн г.м)	2-3	8-12

2.5 Барилга, байгууламжийн ашиглалтын явцад хийх засварын ажлын хугацааг барилгын бүтээц, эдлэлээс хамааруулан, хүснэгт 2-т заасны дагуу зөвлөмжийн чанартай мөрдөнө. Барилга байгууламжид хийх техникийн үйлчилгээг ашиглалтын бүх хугацаанд хийнэ. Барилга байгууламжийн сэргээн засварлалтын ажлын үргэлжлэх хугацааг нийгмийн хэрэгцээгээр, их засварын хугацаатай давхцуулан тодорхойлбол зохино. Сэргээн

засварлалтын ажлын үр дүнгээр ашиглалтын хугацааны нормыг шинэчлэн тогтооно.

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН БҮРДЭЛ ХЭСГИЙН ҮР АШИГТАЙ АШИГЛАЛТЫН
ХУГАЦААНЫ ХАМГИЙН БАГА ҮРГЭЛЖЛЭЛ**

Орон сууцны барилга болон олон нийт, соёл ахуйн зориулалттай объектуудын бүрдэл хэсэг	Их засвар /солих/ хүртэлх ашиглалтын хугацаа /жилээр/	
	Орон сууцны барилга	Хэвийн ба зохистой нөхцөлд ашиглах олон нийт, соёл ахуйн зориулалттай барилга, объектууд
1	2	3
Суурь	50	50
Нийлмэл буюу цементэн зуурмагаар гагнасан бүхэл чулуут шугаман* Шохойн зуурмагаар гагнасан бүхэл чулуут ба тоосгон шугаман* Бетон ба төмөр бетон* шугаман Бүхэл чулуут ба бетон баганан Гадсан* Модон түлгүүр (дэр)	50 60 40 60	50 60 40 60
Хана		
Цементтэй зоргодсон эрдэс хөвөн хавтан дулаалгын үетэй том хавтгаалжин* Хөнгөн бетонон дан үетэй том хавтгаалжин*	50 30	50 30
Салангид сонгомол, чулуун (2.5-3.5 тоосгоны өргөнтэй тоосгон) ба нийлмэл буюу цементэн зуурмагаар гагнасан том гулдмай*	50 40 30	50 40 30
Тоосгон (2-2.5 тоосгоны өргөнтэй тоосгон)*	30	30
Тоосго, үндсэн гулдмай болон хөнгөвчилсэн өрөг* Заамал модон болон дүнзэнцэр модон*	30 15	30 15
Модон угсармал -бамбай, каркас ба дүүргэгчтэй*		
Шавар, шавар тоосго, каркас ба зэгсэн дүүргэгчтэй*		
Уулзварыг бин битүүлэх		
Гадна ханын хавтанг шаваасаар:	8	8
уян налархай	15	15
хөшүүн	25	25
Цонх (хаалга)-ны нүхтэй нийлэх хэсэг		
Хучилт		
Угсармал ба цутгамал төмөр бетон*		
Металл дам нуруун дээрхи тоосгон хүнхэр буюу бетон дүүргэмэл*	80 80	65 65
Модон дам нуруун дээрх модон, давхар дундын шавардлагатай Модон дам нуруун дээрх модон, адрын (шавардлагатай)	60 30 20	50 25 15
Модон дам нуруун дээрх шавардлагагүй, хөнгөвчилсэн	80	65
Металл дам нуруун дээрх модон Дараахь дулаалгын үетэй адрын хучлагын:	25 40	20 30
хөөсөн бетон	15	10
хөөсөн шилэн	40	30
цементэн зоргодсон	15	10
керамзит буюу шаарган	15	10
эрдэс хөвөн		
эрдэс хөвөн хавтан		

Шал		
Бетонон суурин дээрх вааран хавтанцар		
Цементээр бэхжүүлсэн гадарга үетэй	60	30
Цементэн ба гантигийн үйрмэгтэй алаг чулуун	30	15
Ховилтой банзан:	40	20
хучилтын дээр	30	15
хөрсөн дээр	20	10
Зүймэл:	60 (50)	30 (25)
модон дэртэй (бетон дээр наах) царсан	40 (30)	20(15)
модон дэртэй (бетон дээр наах) эвэрлэг	30 (20)	15(10)
модон модон дэртэй (бетон дээр наах) хус, улиасан	20	10
Зүймэл банзан	15	8
Хатуу модон ширхгийн хавтан	30	15
Поливинилцементэн шаваас дээрх цардмал	8	4
Асфальтан	10	5
Аргүй хулдаасан	20	10
Даавуун буюу дулаан тусгаарлах артай хулдаасан	10	10
ПВХ /поливинилхлорид/ хавтанцар	50	25
Чулуун хавтан:	80	40
гантиг		
боржин		
Шат		
Металл, төмөр бетон шатны налуу дам нуруу буюу төмөр бетон хавтан, төмөр бетон шат, гишгүүртэй болон түрдэг тэрэгний замтай*	60	40
Гантигийн үйрмэг бүхий алаг чулуут бетон гишгүүртэй	40	30
Модон	20	15
Тагт, ил тавцан, довжооны шат		
Тагт: Хананаас илүү гарсан ган хөшөөс дам нуруун (раман) дээр цутгамал төмөр бетоноор эсхүл угсармал хавтангаар хийсэн		
Дээрхитэй адил боловч, банзаар хийсэн	60	50
Төмөр бетон өнцгөн тулгууран дам нуруу ба хучилтын хавтанд угсарсан	30	25
Тагт ба ил тавцангийн хашлага:	80	70
төмөр сараалжин	40	35
модон сараалжин	10	8
Шал: Ус тусгаарлагч бүхий цементэн болон хавтанцар тагт	20	15
ба ил тавцан	10	8
Асфальтан	20	15
Хананаас илүү гарсан модон өнцгөн тулгуурт дам нуруун	20	15
дээр банзаар хадаж хийсэн	15	12
Цайрдсан гөлмөн төмрөөр бүрсэн модон	20	15
Хар гөлмөн төмрөөр бүрсэн модон	10	8
Довжооны шат:		
чулуун буюу бетонон гишгүүртэй бетон		
модон		

Дээвэр ба дээврийн хучлага Шувуу нуруу ба дээврийн модон сараалж: угсармал төмөр бетон бүрдэл хэсгээс бүрдсэн угсармал төмөр бетон хучилттай модон Адрын хөндийгүй дээврийн агааржуулалттай (агааржуулалтгүй) хучилгын дулаалгын үетэй: хөөсөн бетон эсвэл хөөсөн шилэн керамзит эсвэл шаарган эрдэс хөвөн эрдэс хөвөнт хавтан	80 80 50 40 (30) 40 (30) 15 (10) 20 (15)	80 80 50 40 (30) 40 (30) 15 (10) 20 (15)
Дээврийн (дээврийн хучлагын) бүрээс Цайрдсан гөлмөн төмөр Хар гөлмөн төмөр Хуйлмал материалан (3-4 үетэй) Вааран (черепицэн) хавтанцар Асбестоцементэн ба долгионт хавтанцар Шиллэг сүлжмэл дээр хийх (хуйлмал биш) цардмал	15 10 10 60 30 10	15 10 10 60 30 10
Ус зайлуулах систем Борооны усны яндан ба нүүрэн талын дагуухь жижиг бүрхүүл: цайрдсан гөлмөн төмөр хар гөлмөн төмөр Дотогш юүлж зайлуулах яндан: ширмэн ган хуванцар	10 6 40 20 10	10 6 40 20 10
Хамар хана Шавардлагатай шаарган бетон, бетонон, тоосгон Гөлтгөнөн, ширхэгт гөлтгөнөн Хуурай шавардлагатай модон каркасан	75 60 30	60 50 25
Хаалга ба цонх Цонх ба тагтны: модон хавтастай төмөр хавтастай Хаалга: дотор хаалга гадна хаалга шатаан дорхи хонгилын хаалга олон нийтийн барилгын гадна/дотор хаалга	40 50 50 40 10 -	30 40 35 30 7 40 (50)
Халаалтын болон гал тогооны пийшин Ханан гал тогооны пийшин: модоор галладаг чулуун нүүрсээр галладаг Халаалтын пийшин: модоор галладаг нүүрсээр галладаг	20 15 30 25	18 12 25 20

Агааржуулалт Адрын хөндий дэх агааржуулалтын яндан ба цонхтой хайрцаг: шаарган бетон хавтан эсгийгээр дулаалж төмрөөр бүрсэн модон агааржуулалтын залгаасан сорох сувгууд: гөлтгөнөн ба шаарган бетон хавтан төмөр торон шавардлагатай, модон	60 40 30 20	60 40 30 20
Гадна засал Өнгөлгөө: цементэн хавтанцар цаасан артай хуйлмал хавтанцар байгалийн чулуун Терразит шавардлага Тоосгон гадаргууг шавардах: Нийлмэл зуурмагаар Шохойн зуурмагаар Модон гадаргуун шавардлага Чимэглэлийн цементэн эд анги Шавардлагатай (бетонон) ханын будалт: Шохойгоор царууц будгаар нийлэг будгаар цахиурлаг химийн будгаар Модон гадаргуун тосон будалт Дээврийн бүрээсийн найруулсан тосон будалт Бүслүүр, сандрик болон цонхны ус хаяурын бүрхүүл: цайрдсан гөлмөн төмөр хар гөлмөн төмөр	60 30 80 50 30 20 15 30 3 6 6 8 4 4 8 6	60 30 80 50 30 20 15 30 3 6 6 8 4 4 8 6
Дотор засал Шавардлага: тоосгон ханын модон хана ба хамар ханын Өнгөлгөө: вааран хавтанцаран хуурай шавардлаган Будалт: усан найрлагатай будгаар Цийдмэг будгаар Шатны хонгилын будалт: усан найрлагатай будгаар цийдмэг будгаар Усны хольцгүй (тосон, алкидан будаг, паалан, лак болон бусад) будалт: хана, тааз, модон эдлэл шал халаах хэрэгсэл, шугам хоолой, шатны хашлага Ханын цаас:ердийн обойгоор сайжруулсан обойгоор	60 40 40 30 4 5 3 4 8 5 4 4 5	30 20 30 15 2 3 3 4 2 3 4 3 4

Инженерийн тоног төхөөрөмж		
Усан хангамж ба бохир ус татуурга		
Хүйтэн ус дамжуулах шугам хоолойн яндан:		
цайрдсан		
ган	30	25
хуванцар	15	12
Ариутгах татуургын шугам хоолой:	60	50
ширмэн	40	30
вааран	60	50
хуванцар	60	50
Усны кран	10	5
Жорлонгийн татуургын кран	10	5
Угаалтуур:	20	10
вааран	30	15
хуванцар	20	10
Жорлонгийн суултуур:	30	15
вааран	20	15
хуванцар	20	15
Жорлонгийн усны сав:	30	20
өндөрт байрлуулсан ширмэн	40	20
вааран	25	12
хуванцар	30	15
Пааландсан ширмэн онгоц	15	8
Ган онгоц	20	10
Гал тогооны угаагуур ба тосгуур:	15	8
пааландсан ширмэн	20	12
пааландсан ган	30	15
зэвэрдэггүй ган	10	10
Ширмэн хаалт ба хаалтуур		
Гуулин хаалтуур		
Шүршүүрийн тэвш		
Ус хэмжүүрийн зангилаа		
Халуун усан хангамж		
Дулаан хангамжийн цайрдсан (ган) хоолойн халуун ус дамжуулах шугам:	20 (10)	15 (8)
битүү цагираган бүдүүвчээр	30 (15)	25 (12)
задгай бүдүүвчээр	15	8
Холигч	15	12
Алчуур хатаагч:	20	15
Ган яндан хоолойгоор хийсэн	10	8
Дицэдсэн хойлойгоор хийсэн	15	12
Ширмэн хаалт ба хаалтуур	10	10
Гуулин 2 урсгалтай тохируулагч хаалтуур	10	10
Дулаан дамжуулах шугамын дулаан тусгаарлалт		
Хурдны ус халаагуур		
Төвлөрсөн халаалт		
Ширмэн (ган) радиатор /халаагуур/:	40 (30)	35 (25)
битүү бүдүүвчээр	30 (15)	25 (12)
задгай бүдүүвчээр	15	10
Дулаан үүсгэвэр	30	25
Төмөр гэрт хавиргат яндан халаагуур		

1	2	3
Ус дамжуулах шугам хоолой		
Босоо шугам:		
битүү	30	25
задгай	15	12
Орон сууцны гол шугам хоолой:	20	12
битүү	15	12
задгай	10	8
Хаалт	10	8
Хаалтуур	10	8
Гурвалсан цорго	30	30
Ус урсгах хоолой	10	10
Шугам хоолойн дулаан тусгаарлагч	25	25
Халаалтын тогоо:	20	20
Ширмэн	6	6
Ган	15	15
Халаалтын тогооны доторлогоо		
Тогооны төмөр хүрээ		
Хог зайлуулах хоолой		
Хавхлагат ам	10	8
Хогны хорго, агааржуулалт	30	25
Босоо хоолой	60	50
Хийн тоног төхөөрөмж		
Байшин доторхи дамжуулах хоолой	20	20
Хийн пийшин	20	15
Ус халаах хийн зуух	10	7
Цахилгаан тоног төхөөрөмж		
Оруулах-түгээх төхөөрөмж		
Хуваарилах самбартай цахилгааны гол шугам оруулга	20	20
Цахилгаан дамжуулах шугам:	20	20
Далд	40	40
ил	25	25
Нийтээр эзэмшдэг газрын жижүүрийн гэрэлтүүлгийн шугам	10	10
Үйлдвэрлэл-техникийн зориулалттай байрны	10	10
Гэрэлтүүлэгийн шугам сүлжээ	15	15
Тэжээлийн шугам сүлжээ:	15	15
цахилгаан шатны тоног төхөөрөмжийн	15	15
утаа зайлуулах системн	15	15
Дулаан түгээх төв /ЦТП/ болон ус халаагуур /бойлер/, барилгын дотор тэжээлийн шугам	10	10
Ахуйн цахилгаан зуух		
Цахилгаан хэрэгслүүд (унтраалга, залгуур, салгуур г.м)		
Диспетчерийн нэгдсэн системийн тоног төхөөрөмж		
Барилга доторх холбоо ба дохиоллын шугам сүлжээ:	15	15
утас самбар, дохио өгөгч, хэмжих шалгах хэрэгсэл болон бусад	10	10
	5	5
Телемеханикийн эвлүүлэг, пульт /хэрэглэл, товчлуур/	5	5
Ярианы нууцлалын тоног хэрэгсэл	4	4
Галын дохиолол хамгаалалтын хэрэгсэл	10	10
Телеантенн		

Инженерийн гадна шугам сүлжээ		
Ус дамжуулах шугамын оруулга:		
ширмэн хоолой	40	40
ган хоолой	15	15
Бохир усны гаргалгааны худаг болон гаргалтын шугам	40	40
хоолой:	30	30
ширмэн	20	20
вааран эсхүл асбестоцементэн	30	30
Дулаан дамжуулах шугам		
Барилгын суурийг уснаас хамгаалах далд шүүрүүлэх шугам		
Гадна тохижилт		
Зам, явган хүний зам, хаяавч /манаас/ -ний аофальтобетон	10	7
ба асфальтон хучилт	15	12
Явган хүний замын зүймэл хавтан хучилт	5	6
Хайрган талбай ба зам	5	4
Хүүхдийн тоглоомын талбайн тоноглол		
Тайлбар: 1.* - барилга байгууламжийг зориулалтаар нь ашиглах бүхий л хугацааных нь турш, өөрчилж болохгүй иж бүрдлийг тэмдэглэсэн болно. 2.Ашиглалтын хүнд нөхцөлтэй үед нийтийн ба соёл ахуйн барилга объектын үндсэн зохицуулалттай орон байранд, 3-р баганад буй хугацааг техник, эдийн засгийн үндэслэлтээс хамааруулан 25 хүртэл хувиар багасгаж болно.		

Гурав. Барилга байгууламжийн техникийн үйлчилгээ

3.1.Барилга байгууламжийн техникийн үйлчилгээ нь барилга байгууламжийг бүхэлд нь болон түүний бүрдэл хэсэг, системийг улирлын ашиглалтад бэлтгэх, тохируулга, зүгшрүүлэлт хийх, бүрэн бүтэн байдал буюу ажиллах чадварыг дээшлүүлэх, техникийн байдлын хяналт, түүнчлэн өрөө тасалгааны ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах ажлыг хамарсан байна. Барилга, байгууламжийн техникийн үйлчилгээний үндсэн ажлын жагсаалтыг дор дурдсанаар зөвлөмжийн чанартай ашиглана.

Барилга, байгууламжийн техникийн үйлчилгээний үндсэн ажлын жагсаалт Салангид бүрдэл хэсэг ба өрөө тасалгааны үзлэгийг явуулахад гүйцэтгэх ажлууд

Ус түгээх ба бохир ус татуургын шугам (систем) -ын бага зэргийн эвдрэл гэмтлийг арилгах (усны цоргоны жийргэвчийг солих, изгон чангалах, бөглөө гаргах, усны савыг цэвэрлэх, сантехникийн хэрэгслүүдийг бэхлэх, сифон цэвэрлэх, холигч дахь бөглөөс цоргыг цэвэрлэх, жийрэг /сальник/ шахах, хөвүүр солих, хэлтэй болон бөмбөлгөн хавхлагын хаймран жийргэвчийг солих, хязгаарлагч төхөөрөг, усны савыг хагнаас цэвэрлэх гэх мэт), байрлал нь алдагдсан тоног хэрэгсэл ба шугам хоолойг бэхлэх.

Төвлөрсөн дулааны болон халуун усан хангамжийн систем дэх бага зэргийн эвдрэл гэмтлийг арилгах (гурвалсан цоргоны тохируулга, жийрэг шахах, дулаан тусгаарлагчид хийх жижиг засвар гэх мэт; цоорсон ган радиаторыг солих, хий хураагуур, бохир тогтоогч, даралт хэмжүүр, тэгшитгүүр, тохируулагч цорго, хаалтуур, хаалтыг шалгах, засах, цэвэрлэх; тулгуур темрийг хагшаасаас цэвэрлэх гэх мэт; багаж хэрэгслүүдийг дамжуулах шугам хоолойд холбогдох хэсэгт нь бэхлэх, мөн дамжуулах шугам хоолойг бэхлэх)

Цахилгаан техникийн хэрэгслийн бага зэргийн эвдрэл гэмтлийг арилгах (нийтийн хэрэглээний орон байран дахь цахилгаан чийдэнг цэвэрлэх, шатсаныг нь солих, залгуур ба унтраалгыг засах, солих, цахилгааны шугамд жижиг засвар хийх гэх мэт)

Худгийг агааржуулах.

Бохир ус татуургын шугамын хийн соролтын байдлыг шалгах.

Утааны яндан, агааржуулалтын сувгийн таталтын бэлэн байдлыг шалгах.

Онгоцны газардуулгыг шалгах.

Пийшин ба зуухны жижиг засвар (амыг бэхлэх, тосгуур төмөр гэх зэрэг)

Ариутгах татуургын шугамд тунасан хогийг цэвэрлэх

Төмөр дээврийн хучлагын гагнаасын хэсгийг шалгах, нүх цоорхойг нөхөх.

Цахилгаан кабелийн шугамын газардуулга, тусгаарлалтын эсэргүүцлийг шалгах.

Тоног төхөөрөмжийн газардуулгыг шалгах (шахуурга, сэнсний удирдах самбар)

Шатны хонгил, техникийн давхар адрын хөндийн чийдэнг солих ба цэвэрлэх

Цахилгаан дамжуулах шугамын жижиг гэмтлийг засах

Залгуур ба унтраалгыг засах.

Хавар-зуны улирлын ашиглалтад барилга байгууламжийг бэлтгэхэд гүйцэтгэх ажлууд

Борооны усны яндан, өндгөвч, юүлүүрийг бэхлэх.

Усалгааны (зүлэгний) системийг хадгалалтаас гаргаж, бэлэн болгох.

Гадна хаалганы татуургыг авах.

Төвийн халаалтын системийг хадгалалтад тавих.

Хүүхдийн тоглоомын ба биеийн тамирын талбайн тоног төхөөрөмжийг засварлах.

Зүймэл, цардмал явган хүний зам, замын хашлагыг засварлах.

Усалгааны (зүлэгний) системийн нэмэлт сүлжээний төхөөрөг солих.

Адрын хөндийн агааржуулт ба хаявчийг хог хаягдлаас цэвэрлэх.

Зоорийн давхрын шал болон нүүрэн талын хучлагад үзлэг хийх.

Намар -өвлийн улирлын ашиглалтад барилга, байгууламжийг бэлтгэхэд гүйцэтгэх ажлууд

Цонх болон тагтыг дулаалах.

Цонх, шилэн блок болон тагтны хаалганы хагарсан шилийг солих.

Байр сууцны хаалгыг дулаалах.

Адрын хөндийн хучилтыг дулаалах ба засварлах.

Адрын хөндий болон зоорийн давхар дахь дамжуулах шугам хоолойг дулаалах ба засварлах.

Парапетны хашлагыг дулаалах ба засварлах.

Адрын хөндийн цонхон гарцыг хаах, шиллэх.

Зоорь болон адрын хөндий рүү орох гүүрэн дамнуур, дамжих банзыг засварлах, эсвэл шинээр хийх.

Усан хангамж ба төвлөрсөн дулааны системийг турших, тохируулах ба засварлах.

Гал тогооны зуух ба пийшинг засварлах.

Ус халаагчийг дулаалах ба засварлах.

Утаа зайлуулах сувгийг цэвэрлэх, дулаалах ба засвар хийх.

Шилэн блок, цонхны шил, орох хаалга ба туслах орон байрны хаалганы хагарсан шилийг солих

Усалгааны сүлжээг хадгалалтад тавих.

Барилгын хаяавчны салхи нэвт үлээдэг хэсгийг бөглөх.

Усхуваарилах цорго болон тулгуурыг дулаалах ба засварлах.

Хаалганд татуурга хийх, засварлах.

Бусад ажил

Туршилтын өмнө төвлөрсөн халаалтын системийг тохируулах ба зүгшрүүлэх.

Агааржуулалтын төхөөрөмжийг тохируулах ба зүгшрүүлэх.

Төвийн халаалтын системийг угаах.

Усны тэлэх савыг угаах, цэвэрлэх.

Инженерийн тоног төхөөрөмжийн автомат удирдлагын системийг тохируулах ба зүгшрүүлэх.

Худаг цэвэрлэх.

Улирлын ашиглалтад талбайн усзайлуулах сүлжээг бэлтгэх

Дээврийн цас мөсийг цэвэрлэх.

Дээврийн хучлагыг хог, шороо, навчис, ургамлын үлдэгдлээс цэвэрлэх.

3.2.Барилга байгууламжийн техникийн үйлчилгээний хяналтыг орчин үеийн нарийн мэдрэмжтэй багажийг ашиглан ээлжит, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үзлэгийг тасралтгүй зохион байгуулах замаар хийнэ.

3.3.Ээлжит үзлэгийг барилга байгууламжийн бүтээцийн бат бэх байдал, тогтвортой найдвартай ажиллагаанаас хамааруулан ангилсан барилга байгууламжид 2-5 жил тутам эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

3.4.Төлөвлөгөөт үзлэгийг ерөнхий ба хэсэгчилсэн гэж ангилна. Ерөнхий үзлэгээр барилга байгууламжийн техникийн байдлыг бүхэлд нь, түүний систем, гадна тохижилтын хамт; хэсэгчилсэн үзлэгийн үед байшин барилгын техникийн байдлыг хийц хэсэглэл, гадна тохижилтын бүрдэл хэсэг тус бүрээр хянан.

3.5.Төлөвлөгөөт бус үзлэгийг гал түймэр, аадар бороо, хүчтэй салхи, угалз, цасны нур, усны үер, газар чичирхийлэл зэрэг байгалийн гамшиг, аюулт үзэгдэлд үйлдвэрлэлийн ослын ул мөр арилаагүй үед барилга байгууламжид гарсан гэмтэл, согогийг илрүүлэн арилгах зорилгоор хийнэ.

3.6.Ерөнхий үзлэгийг жилд 2 удаа хавар, намрын цагт явуулна.

Хаврын үзлэгээр барилга, байгууламжийн хавар-зуны ашиглалтын бэлэн байдал,

намар-өвлийн ашиглалтын бэлтгэл ажлыг тогтоох, тухайн жилд явуулах урсгал засварт орсон барилга байгууламжид хийх засварын ажлын хэмжээг тодотгоно.

Намрын үзлэгээр барилга, байгууламжийн намар-өвлийн ашиглалтын бэлэн байдал, дараа онд хийх урсгал засварын ажлын төлөвлөгөөнд орсон барилга байгууламжид хийх засварын ажлын хэмжээг тодотгоно. Ерөнхий үзлэгийн үед хөлслөгчид ба түрээслэгчид эд хөрөнгө хөлслөх, түрээслэх гэрээний нөхцлийг хэрхэн биелүүлж байгааг хянавал зохино. Барилга ба объектийн өрөө тасалгаа, бүрдэл хэсгийн төлөвлөгөөт үзлэгийг явуулах хугацааг тогтоохдоо хүснэгт 3-д заасныг зөвлөмжийн чанартай мөрдөнө.

Хүснэгт 3

**Барилга ба объектийн өрөө тасалгаа болон бүрдэл хэсэгт
үзлэг явуулах хугацаа**

Барилга ба объектийн өрөө тасалгаа ба бүрдэл хэсэг	Үзлэг явуулах хугацаа,сар	Тайлбар
Дээвэр	3-6*	-
Модон бүтээц ба мужааны хэрэгсэл	6-12*	-
Өрөгт бүтээц	12	-
Төмөр бетон бүтээц	12	-
Угсармал барилгын хавтан болон хавтан	12	-
Угсармал барилга дахь зэврэлтийн эсрэг хамгаалалтгүй ган торговч ба бэхэлгээний эд анги	Ашиглаж эхэлснээс хойш 10 жилийн дараа, дараа нь 3 жил_тутам	Үзлэгийг 5-6 зангилгааг задлах замаар явуулна.
Зэврэлтийн эсрэг хамгаалалттай бэхэлгээний ган эд анги	Ашиглаж эхэлснээс хойш 15 жилийн дараа, дараа нь 3 жил тутам	-
Пийшин, гал тогооны зуух, утааны хүхээг, утааны яндан	3	Үзлэг болон цэвэрлэгээг эхлэхийн өмнө болон галлагааны улирлын турш явуулна.
Хийн суваг	3	-
Агаар сэлгэх суваг	12	-
Хийн хэрэгсэл байрлуулсан байран дахь	3	-
Дотор ба гадна засал	6-12*	-
Шал	12	-
Шатны хонгилын цонхны хаалт сараалж	6	-
Халуун усан хангамж, бохир ус татуурга, ус дамжуулах систем	3-6*	-
Төвлөрсөн халаалтын систем: нийтийн ба соёл ахуйн зориулалттай үндсэн зохицуулалттай байр болон орон сууцан дахь. шат, адрын хөндий, зоорины.	3-6* 2	Үзлэгийг халаалтын улирлын турш явуулна.
Дулааны оролт, тогоо, тогооны тоног	2	-
Хог, хаягдлын хоолой	Сар бүр	-
Цахилгаан тоног төхөөрөмж: Цахилгааны ил утас Цахилгааны далд болон төмөр шонд өлгөөстэй цахилгааны утас Гал тогооны цахилгаан пийшин Туслах байрны (шат, үүдэн танхим	3 6 6 3	—

1	2	3
Утаа зайлуулах болон гал унтраах тоноглолын иж	Сар бүр	-
Домофон ба бага хүчдлийн мэдээллийн сүлжээ	Сар бүр	-
Халаалтын тогоо, ус халаагуур, засварын газар, ус шахалтын туршилтын болон шүүрүүлэх төхөөрөгийн цахилгаан төхөөрөмж	2	
Шат, гонх, үүдэн танхим, зоорь, адрын хөндий болон бусад туслах орон байр	12	-
Тайлбар: 1.* - барилгын техникийн байдал болон орон нутгийн нөхцлийг үндэслэн ашиглагч байгууллага энэ хугацааны дотор үзлэгийн тодорхой хугацааг тогтоох бүрдэл хэсгийг тэмдэглэсэн болно. 2.Барилга, объектын тусгай төрлийн технологийн тоног төхөөрөмжийн үзлэгийн хугацааг хариуцсан байгууллага нь тогтооно.		

3.7.Хэсэгчилсэн үзлэгийг цаг хугацааны туршид бий болсон эвдрэл гэмтлийг илрүүлэх зорилгоор явуулна.

Хэвийн нөхцөлд ашиглах барилга байгууламжийн эвдрэл, гэмтлийг арилгах хугацааг тогтоохдоо хүснэгт 4-д заасныг зөвлөмжийн чанартай мөрдөнө.

Хүснэгт 4

Барилга ба объектийн бүрдэл хэсгийн гэмтэлийг арилгах хугацаа

Барилгын бүрдэл хэсэг, түүний эвдрэл гэмтлүүдийн нэр төрөл	Эвдрэл гэмтлийг (үүссэн мөчөөс эхлэн) арилгах цаад захын хугацаа, хоног
Дээврийн хучлага Ус (дусаал) гоожих Эвдрэл гэмтэл: Зориулалтын ус зайлуулах системд (борооны усны яндан, юүлүүр, өндгөвч, усны хагалбар зэрэг) Дотуур зайлуулах Гадагш (задгай) зайлуулах	1 5 2 5
Хана Хүмүүсийн аюулгүй байдалд аюул учруулж болзошгүйгээр гадна ханын тоосго сугарч, эсхүл эмтэрч устах гэмтэх Ханын хавтангийн завсраар ус нэвчих Утаа болон хийн хоолойд нягт бус байдал илрэх	1 (аюултай бүсийн хаалтыг яаралтай хийнэ) 7 1
Цонх ба хаалга Хагарсан шил, цонхны жаазны салсан хавтас, цонхонцор, тагтны хаалганы самбар, витраж, витрины шил ба рамын гэмтлийг: өвлийн цагт зуны цагт	1 3
Пийшин Байр сууц руу утаа орж ирэх, галын аюул нүүрлэж болзошгүйгээр зай завсар болон өөр бусад гждряп гамтяп гарах	1 (ашиглалтыг яаралтай зогсооно)

Дотор, гадна засал Нурах байдалтай болсон ханын дээд хэсэг буюу таазны шавардлагын хууралт Гадна өнгөлгөө болон 1.5 м-ээс дээш оидорт оргогдсон ханатай, нүүрэн тал дээр байрлуулсаи баримал чимэглэл гажиж эвдрэх Хаяавчийн хэсэгт гажилт үүсэх	5 (аюулгүй байдлыг хангах арга хэмжээг яаралтай авах) Аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч, яаралтай засах 5
Сантехникийн тоног төхөөрөмж Усны кран болон жорлонгийн усны савнаас ус алдах Эвдрэл гэмтлүүд: Ус дамжуулах шугам хоолойд ослын шинжтэй гэмтэл гарах Хогны хоолойн Фекаль болон шүүсэн усны төхөөрөг	1 яаралтай 1 1
Цахилгаан техникийн төхөөрөмж Эвдрэл гэмтлүүд: Ослын шинжтэй (богино холбоо зэрэг) цахилгааны гэмтэл Ослын бус шинжтэй цахилгааны гэмтэл Диспетчерийн нэгдсэн системийн Галын дохиолол хамгаалалтын Ярианы нууцлалын хэрэгслийн Цахилгаан зуухны	яаралтай 1 яаралтай яаралтай 1 1
Цахилгаан шат Цахилгаан шатны эвдрэл гэмтэл	1 (ашиглалтыг заавал яаралтай зогсооно)

3.8.Ерөнхий үзлэгийг орон сууцны барилгад мэргэжлийн байгууллага болон сууц өмчлөгчдийн холбооны төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй комисс, бусад барилгад тухайн аж ахуйн нэгж, байгууллагын барилга байгууламжийн ашиглалт хариуцсан ерөнхий инженерийг оролцуулсан комисс явуулна. Шаардлагатай үед комиссын бүрэлдэхүүнд барилга-засварын байгууллагын төлөөлөгч, эксперт-мэргэжилтэнг оруулж болно.

3.9.Хэсэгчилсэн үзлэгийг орон сууцны барилгад мэргэжлийн байгууллагын ажилтнууд, бусад барилга, байгууламжид тухайн байгууллага, аж ахуйн нэгжийн ашиглалтын албаны ажилтнууд зохион байгуулна.

3.10.Үзлэгийн үр дүнг илтгэсэн баримт бичгийг техникийн байдлын бүртгэлээр барилга байгууламжийн хувийн хэрэгт тэмдэглэнэ. Энэ баримт бичгүүд нь барилга, байгууламж болон түүний хийц хэсгийн техникийн байдлын үнэлгээ, эвдрэл гэмтэлийн тодорхойлолт, түүний байрлал, үүсэх болсон шалтгаан, түүнчлэн засварын ажлын гүйцэтгэлийн чанарын талаархи мэдээллийг агуулсан байна.

Барилга, байгууламжийн байдлын тухай ерөнхийлсөн дүгнэлтийг жил бүр түүний хувийн хэрэгт тусгана.

3.11.Барилгын тоног төхөөрөмж ба инженерийн хангамжийн (элеваторийн зангилаа, дулаан түгээх төв /ЦТП/, бойлор, халаалтын тогоо, халуун усан хангамж, халаалтын систем, лифт, утаа зайлуулах ба гал унтраах систем, шатны хонгилын гэрэлтүүлэгч г.м) төвлөрсөн удирдлагад, түүнчлэн барилгын бүрдэл хэсгийн эвдрэл, гэмтлийг засах ажилд хяналт тавих зорилгоор сонирхогч байгууллагууд хамтран диспетчерийн албыг ажиллуулвал зохино. Диспетчерийн алба нь удирдлагын ба хяналтын орчин үеийн техникийн багаж хэрэгслээр хангагдсан байна.

3.12.Техникийн үйлчилгээний зардалд ослын үед хийгдэх ажлыг гүйцэтгэхэд зориулсан хэрэгслийн нөөцийг тусгана. Барилга, байгууламжид гарсан осол, эвдрэл гэмтлийг төвлөрүүлэн засахад зориулан ослын техникийн албыг байгуулвал зохино.

3.13.Ерөнхий гүйцэтгэгч нь барилга байгууламжийг барьж байнгын, эсхүл барилга (объект)-д их засварыг хийж ашиглалтад оруулснаас хойш барилга байгууламжийн ажлын (засварын ажлын) чанарын баталгаат хугацаанд буюу 1 жилийн дотор гарсан гэмтэл, дутуу хийсэн ажлыг өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэнэ.

3.14.Барилга байгууламжийн техникийн үйлчилгээний төлөвлөлтийг техникийн үйлчилгээгээр жилийн болон улирлын графикт-төлөвлөгөөт ажлыг: боловсруулах замаар хийвэл зохино.

Дөрөв.Барилга байгууламжийн урсгал засвар

4.1.Урсгал засварыг барилга, байгууламжийн үр ашигтай ашиглалтыг хангахын тулд түүнийг барьж (их засвар хийж) дууссан мөчөөс эхлэн ээлжит их засвар (өргөтгөл, шинэчлэл) хийх хүртэлх хугацаанд тасралтгүй хийнэ. Урсгал засварыг хийхдээ байгаль - цаг уурын нөхцөл, бүтээцийн шийдэл, техникийн байдал ба барилга, объектын ашиглалтын горимыг харгалзан үзнэ.Урсгал засварын ажлын жагсаалтыг дор дурдсанаар зөвлөмжийн чанартай хэрэглэх бөгөөд шаардлагатай нөхцөлд тодруулга, нэмэлт оруулахыг зөвшөөрнө.

Барилга, байгууламжийн урсгал засварын , үндсэн ажлын жагсаалт Зоорь, суурийн хана

- 1.Зоорийн хананы дотор ба гадна талд бий болсон ан цав, заадлын гэмтлийг засах, ховхорсон өнгөлгөөний хавтанцарыг наах.
- 2.Ханыг хүчитгэх, өргийг солих замаар хэсэгчилсэн ан цавыг арилгах.
- 3.Зоорийн өрөөний ус тусгаарлалтын гэмтлийг засах.
- 4.Нүх, үүр, ховилыг бөглөх, дүүргэх.
- 5.Салхижуулалт, шахуургын тоног төхөөрөмжийн суурийг хүчитгэх.
- 6.Бат бөх материалтай ханын талаас шугаман, шаталсан суурийн тусгай хэсгүүд болон модон барилгын тулгуур хөлийг солих.
- 7.Агааржуулалтын үлээгүүр, богино хоолойг шинээр хийх болон солих.
- 8.Зоорийн орц, нүхийг засварлах.
- 9.Барилгын эргэн тойрны дагуу хаяавчийн хэсгүүдийг солих
- 10.Зоорийн байгууламжийн болон техникийн нуувчинд орох хэсгийг бин битүүлэх.
- 11.Ан цавын судалгаа явуулах зорилгоор хананд шав ба тэмдэг байрлуулах

Хана

- 1.Ан цавыг бөглөх, заадсыг шавардах, 2м² хүртэл талбайтай тоосгон ханын тусгай хэсгүүдийн өрөг, өнгөлгөөг сэргээн засварлах.
- 2.Гулдмай, хавтангийн гадаргууны ан цав, сэвийг бөглөх, угсармал барилгын элементүүдийн уулзварыг бин битүүлэх.
- 3.Нүх, үүр ховилыг бөглөх.
- 4.Модон яс зангидлага ба дүнзэн ханын муудсаныг солих, завсар зайг чигжих, дулаалах, бэхлэх, модон ханын хевөөний хэсгүүдийг солих.
- 5.Зарим дөр хана, ялуу, хүрээг сэргээх.
- 6.Унасан зарим чулууг нөхөн шигтгэх.
- 7.Ханын хөлдөж цантдаг хэсгийг дулаалах.
- 8.Чийг даадаг болон салхи нэвт үлээдэг хэсгийг засварлах.
- 9.Агааржуулалтын суваг, татацын төхөөрөмжийг засварлах, цэвэрлэх.

Хучилт

- 1.Хучилтанд түр бэхэлгээ хийх.
- 2.Модон хучилтын зарим элементийг хүчитгэх, хэсэгчлэн солих. Асгаас болон түрхлэгийг сэргээх. Үжлийн эсрэг болон галын эсрэг хамгаалалт хийх.
- 3.Угсармал төмөр бетон хучилтын уулзварын заадсыг бөглөх.

- 4.Төмөр бетон бүтээцийн ан, цав, сэвийг бөглөх.
- 5.Адрын ган дам нурууны дээд тавиурыг дулаалах, будах.
- 6.Адрын хучилтыг асгаасаар нэмж дулаалах

Дээвэр

- 1.Шувуу нурууны хөл, тулгуур, ташуу холбоосын болон гол дам нуруу, хэвтээ холбоос, мауэрлат болон сараалжийг хүчитгэх.
- 2.Модон хийц, бүтээцэд үжлийн эсрэг болон галын эсрэг хамгаалалт хийх.
- 3.Төмөр, асбестоцементэн зэрэг ширхэгийн материалан дээврийн эвдрэл гэмтлийг арилгах бүх төрлийн ажил, тэдгээр дээврийн парапет, ханатай нийлэх хэсэг ба дээврээс илүү гарсан утааны яндангийн шүхэр, дээвэрт гарах цонх, түүнчлэн дээш цухуйх яндан хоолойн зааг зэргийг засаж янзлах.
- 4.Ус хаях хоолой, нүүрэн талын архитектурын элементүүдийн жижиг хэсгийг бэхлэх, солих.
- 5.Хуйлмал материалыг хэсэгчлэн солих.
- 6.Хуйлмал бус дээврийн хучлагын зарим хэсгийг солих.
- 7.Парапетийн сараалж, галын шат, өлгөөс шат, шахлуур, дээврийн хашлага, газардуулгын тоноглол, радио болон теле-антенныг бэхлэх, солих.
- 8.Хуйлмал болон хуйлмал бус хучлагын хамгаалалт-өнгөлгөөний үеийг сэргээх, шинээр хийх.
- 9.Дээвэр лүү гарахад зориулагдсан цонхон гарц, тусгай тагийг засах, солих.
- 10.Хучлагыгцас.мөстөлтөөсцэвэрлэх.

Цонх, хаалганы эвлүүлэг, гэрэлтүүлэх бүтээц хийц

- 1.Төмөр ба модон цонх, хаалганы эвдэрсэн самбар болон бүрдэл хэсгийг засварлах ба солих;
- 2.Дулаан тохируулагч агрегат, татуурга, тулгуурыг тоноглох.
- 3.Хаалга.цонхныхэрэгслийгзадлах.
- 4.Хагархай шил, шилэн блокийг солих.
- 5.Салхивчийг суулгах.

Хамар хана

- 1.Модон хамар ханыг буулгах, хүчитгэх, бэхлэх;
- 2.Хавтангаар хийсэн хамар ханын ан цавыг бөглөх, тусгай хэсгүүдийг нөхөн өрөх;
- 3.Хамар ханын дуу чимээнээс тусгаарлах чанарыг сайжруулах;

Дээд давхрын тагт, орцны дээрх саравч,

халхавч, орцны шат, тагт, гадна довжооны ажил

- 1.Шатны талбай, гишгүүрийн ан цав, сэвийг бөглөх, засварлах.
- 2.Гишгүүр, түүний хэвтээ болон хажуугийн элементийг хэсэгчлэн солих.
- 3.Ил тавцан ба тагтны нүүр хавтан, сараалж, төмөр хашлагыг бэхлэх, хэсэгчлэн солих;
- 4.Модон шатны эд ангийг хэсэгчлэн солих.
- 5.Бетон ба төмөр бетон тагтны хавтангийн ан цав, сэвийг бөглөх, засварлах.
- 6.Тагтны хавтангийн шалны ус тусгаарлалт ба цайрдсан буултуурыг сэргээх, довжооны шатны болон саравчны хучлагыг засварлах, гөлмөн төмөр бүрээсийг солих.
- 7.Дээд давхрын тагт, зоорь, орцны хаалганы саравчийг сэргээх, шинээр хийх, довжооны шатны тусгайлсан эд ангийг солих, сэргээх.
- 8.Шатны болон тагтны бариулыг бүрэн ба хэсэгчлэн солих.
- 9.Гарц ба орцны хэсэг, гонх зэргийг жил бүр засварлах.

Шал

- 1.Шалны зарим хэсгийг солих.
- 2.Сантехникийн өрөөний хучилтыг бүрэн солих замаар ус тусгаарлалтыг солих.
- 3.Асфальтэн, бетонон ба цементэн шал, түүнчлэн шалны суурь үеийн ан цав сэвийг

засварлах.

4.Модон шалыг шахах.

Пийшин, галлагаа

1.Пийшин, гал тогооны зуухны эвдрэлийг арилгахтай холбогдсон бүх төрлийн засвар.

2.Утааны яндан, залгах яндан ба хүхээгийг хэсэгчлэн өрөх.

Дотор өнгөлгөө

1.Хана, таазны зарим хэсгийг сэргээн шавардах.

2.Ханын вааран болон бусад хавтангийн өнгөлгөөг сэргээх.

3.Карниз, унтраалгын суурь, өө сэвны шаваасыг бэхлэх, сэргээх.

4.Орон сууцнаас бусад барилгад хийгдэх шавар-будгийн ажлын төрлүүд. Орон сууцны барилгад энэ ажлыг суугч өөрөө хариуцна.

Гадна засал

1.Гадна ханыг элсээр шүршиж, эсхүл угааж цэвэрлээд будах.

2.Ханын шавардлага ба хавтанцарыг хэсэгчлэн засварлах.

3.Унаж аюул учруулж болзошгүй чимэглэлийн эд анги, өнгөлгөөний хавтан ба зарим тоосгыг авч солих.

4.Хаяавч, хаалт, ус хаях хоолой, парапетийн тор, тагтны хаалт, хаалга, цонхыг тосон будгаар будах.

5.Байшингийн дугаар, гудамжны хаягийг сэргээх.

Төвлөрсөн халаалт

1.Халаах хэрэгсэл ба хаах тохируулах арматур, түүнчлэн муудсан яндан хоолойг солих.

2.Зайлшгүй нөхцөлд хийн кран байрлуулах.

3.Тэлэх сав, хэмжих хэрэгсэл, яндан хоолойгдулаалах.

4.Тогооны доторлогоо, үлээх суваг, утааны яндангийн хүхээг засах.

5.Ширмэн тогооны холбох хэрэгсэл, хэмжих шалгах багаж, сараалж, үнсний савыг солих.

6.Гэмтсэн дулаалгыг сэргээх.

7.Гидравликийн туршилт хийж системийг угаах.

8.Халаах хэрэгслийг босоо шугамаар нь хөөж бүхэлд нь угаах.

9.Халаалтын системийн тохируулга, зүгшрүүлэлт

Агааржуулалт

1.Агааржуулалтын хайрцаг, уурхай (хонгил) хадгалуур, агаар дамжуулах шугамын нягтруулгыг засах, зарим хэсгийг буулгаж солих.

2.Сэнс, агаарын хавхлаг, бусад тоноглолыг солих.

3.Сорох хэрэгсэл, яндангийн толгойг солих, засах.

4. Автомат гал унтраах, утаа зайлуулах системд зүгшрүүлэлт хийж, засварлах.

Цэвэр, бохир ус, хэрэгцээний халуун усан хангамж

(барилгын доторхи систем)

1.Залгаасыг нягтруулах, гоожилтыг зогсоох, яндан хоолойг бэхлэх ба дулаалах, гэмтэлтэй яндан ба сифон, трап, ревизийг солих; гэмтсэн дулаалгыг шинэчлэх, сүлжээг шахаж шалгах, бөглөрлт ба лагийг арилгах, шүүрийг угаах, хог хаягдлыг арилгах.

2.Ус авах цорго, холигч, тулгуур арматур, шүршүүрийг хэсэгчлэн солих

3.Адрын усны даралтат савны арматурыг солих, дулаалах.

4.Зам талбай услахад зориулж ус дамжуулах гадна оруулгыг уртасгах, тэдгээрийг хэсэгчлэн солих.

5.Дотор галын крантыг солих

6.Бага хүчин чадлын цахилгаан хөдөлгүүр, шахуургыг солих, засварлах

7.Халуун усны зангилаа, ус халаагч ба утааны могой гуурсийг солих, түүний хөө тортгыг цэвэрлэх.

8.Бохир усны гаргалгааны шугам хоолой, худаг, шүүрүүлэлтийн системийг цэвэрлэх.

- 9.Зэврэлтээс хамгалах түрхлэг, марклалт хийх.
- 10.Тохируулах арматурыг солих, засах.
- 11.Цэвэр, бохир усны системийг угаах.
- 12.Хэмжих, шалгах багажийг солих.

Цахилгаан техникийн болон сул хүчдлийн гүйдлийн тоноглол

- 1.Барилгын цахилгаан шугамын эвдрэлтэй хэсгийг солих, шинээр тоноглох.
- 2.Орон сууцны цахилгаан зуух, пийшингийн тэжээлийн шугамын гэмтэлтэй хэсгийн солих
- 3.Ажиллагаагүй болсон тийзэн таг, унтраалга, залгуурыг солих.
- 4.Ажиллагаагүй болсон гэрэлтүүлэг, баярын чимэглэл, гэрлэн чимэглэлийг солих.
- 5.Цахилгаан пийшин, самбар, оруулгын хуваарилах тоноглолын бүлэглэсэн болон автомат сэлгэн залгуур, гал хамгаалагчийг солих.
- 6.Байшингийн гэрэлтүүлэгийн алсын болон автомат удирдлагын бусад төхөөрөмж, хугацааны реле, фотосалгуурыг солих, тоноглох.
- 7.Цахилгаан хэрэгслийн хэсэгчилсэн зангилаа, цахилгаан хөдөлгүүрийг солих.
- 8.Суурилагдсан цахилгаан пийшингийн хяналтын ба дохиоллын гэрэл, сэлгэн залгуур, шарах шүүгээний халаагуур болон бусад эд ангийг солих.
- 9.Суурин цахилгаан пийшинг бүхэлд нь солих.
- 10.Тооцооны багаж тоолуур, хэрэгслийг солих.
- 11.Төвийн халаалттай орон сууцны дотор шугамд байрлуулсан хяналт-шалгалтын болон дохиолол, автоматжуулалтын тоног хэрэгслийг солих, угсрах.
- 12.Барилгын техникийн тоноглолыг шуурхай болон хуваарилах удирдлын системд холбох.
- 13.Төвлөрсөн халаалтын болон ус хангамжийн дотор шугамын ган яндан хоолойг зэврэлтээс хамгаалах, цахилгаан хангамжийн байгууламжийг засварлах.
- 14.Орон сууцны барилгын нийтийн хэрэглээний телеантен, холбоожуулалт, радионы шугамын байгууламж тавих, засварлах.
- 15.Газардуулгын сүлжээг сэргээх.
- 16.Галын болон хамгаалалтын дохиоллын тоноглол, дамжуулах шугам, дохиоллуурыг солих.

Гадна тохижилт

- 1.Явган хүний зам, гарц, зам-талбайн эвдрэлтэй хэсгийг сэргээх.
- 2.Хүүхдийн тоглоом, биеийн тамирын болон аж ахуйн талбай, хашаан дахь угаалгын газар, хогийн сав, хог зөөхөд зориулагдсан чингэлээгийн талбайг солих, байрлуулах, засварлах.
- 3.Амрах зугаалах талбайг тоноглох.

Бусад ажил

- 1.Зоорийн хэсэг рүү орох орцын саравч ба шат, зоорийн цонхны хамгаалалтын төмөр сараалж бэхлэх, угсрах.
- 2.Төвлөрсөн дулааны яндан хоолой, салхижуулалтын хайрцаг, түүний залгавч хэсгийн адар руу шилжих гарцыг шинээр хийх, сэргээх.
- 3.Хог дамжуулах худгийн хаалтыг бэхлэх, түгжээг солих, хогны хоолойн цэвэрлэгээний тоноглолыг засах.
- 4.Байшингийн доторх бүх төрлийн тоноглолыг зүгшрүүлэх.
- 4.2.Урсгал засварыг таван жилийн (жил жилээр хуваарилан) болон жилийн төлөвлөгөөгөөр хийвэл зохино. Жилийн төлөвлөгөөгөөр урсгал засварыг хийхийн тулд явуулсан үзлэгийн үр дүнгээр, төсвийн техникийн баримт бичгүүдийг боловсруулан таван жилд хийгдэх ажлыг тодотгож, улирлын ашиглалтад барилга, объектийг бэлтгэх арга хэмжээг зохион байгуулна.
- 4.3.Орон сууцны барилгын урсгал засварын ажлыг дууссаны дараа, уг ажлыг мэргэжлийн

болон барилга засварын ажлыг гүйцэтгэсэн байгууллага, түүнчлэн сууц өмчлөгчдийн холбооны төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй комисс хүлээн авна. Олон нийт, соёл ахуйн зориулалттай объектийн урсгал засварын ажил дууссаны дараа, уг ажлыг мэргэжлийн ба барилга засварын ажлыг гүйцэтгэсэн байгууллага болон харъяа удирдах дээд байгууллагын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй комисс хүлээн авна.

4.4.Барилгын урсгал засварыг гэрээгээр гүйцэтгэхдээ үнэ бүрдлийн зарчим ба гүйцэтгэсэн ажлын хөлс олгох журмыг мөрдвөл зохино.

4.5.Сууцны болон туслах байрны өрөөнүүдийн урсгал засварын ажлыг тухайн орон байрыг эзэмшигч өөрийн хөрөнгөөр холбогдох хууль дүрмийн хүрээнд гүйцэтгэвэл зохино. Эзэмшигчийн өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх, засварын ажлын нэр төрөл, хэмжээг зөвлөмжийн чанартай мөрдөхөөр дор тусгав. Эдгээр ажлуудыг ашиглагч байгууллага, аж ахуйн нэгжүүд барилгын бүрдэл хэсэг (дээврийн хучлага, инженерийн шугам сүлжээ болон бусад)-т гэмтэл учруулсан бол тухайн байгууллага нь холбогдох техникийн үйлчилгээ болон засварын ажлыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэнэ.

Хөлслөгчийн хөрөнгөөр хөлслүүлэгчийн гүйцэтгэх орон сууцны засварын ажлын жагсаалт

- Сууцны болон туслах өрөөний хана, тааз, ил тавцан, тагтны хэсэглэлийг будах.
- Хана таазыг цааслах.
- Цонхны хавтан, тагтны хавтасыг дотор, гадна талаас нь, сууцны болон туслах өрөөний шал будах, зүймэл шалыг өнгөлөх.
- Ус хангамж, сувагжуулалт, төвлөрсөн халаалтын яндан, халаах хэрэгслийг будах.
- Цонх, хаалга, зуух пийшингийн хэрэгслийг солих, шиллэх. Нэмэлт цорго, холигч болон бусад тоноглолыг солих, угсрах, хаалганы хавтас, ханын шүүгээ болон орон сууцны тохижилтод зориулж өнгөлгөө хийх.
- Орон сууцны оруулгын цахилгаан утас, цахилгаан багаж, хэрэгслийг солих, засварлах.
- Орон сууцны заслыг сайжруулах.
- Орон сууцны байшингийн хамар хана, тааз, ханын шохойг засварлах, тусгайлсан тусгай гөлмөөр бүрэх.
- Шалыг солих, засварлах.
- Хөлслөгчтэй зөвшөөрөлцсөний дагуу зохих журмаар төлөвлөлт, тохижилтыг өөрчлөх арга хэмжээ авах.

Тав.Барилга, байгууламжийн их засвар ба сэргээн засварлалт

5.1.Их засварт эвдэрсэн бүрдэл хэсгийн бүх гэмтлийг арилгах, сэргээн босгох болон засвар хийгдэх барилгын ашиглалтын үзүүлэлтийг илүү ашигтай, бат бэх болгон солих (чулуун ба бетонон суурь, даацын хана ба каркасыг солихоос бусад) ажлуудыг оруулна. Энэ үед барилга байгууламжийн үр ашигтай сэргээн засварлахад нийцсэн төлөвлөлтийг сайжруулах, үйлчилгээ-ашиглалтын чанарыг дээшлүүлэх, инженерийн тоног төхөөрөмжийн зарим хэсгийг шинэ боловсронгуй тоног хэрэгслээр тоноглох, орчны тохижилтын ажлуудыг гүйцэтгэж болно. Их засварын үед хийгдэх нэмэлт ажлуудын жагсаалтыг зөвлөмжийн чанартай мөрдөхөөр дор тусгав.

Барилга, байгууламжийн их засварын үед хийгдэх нэмэлт ажлын жагсаалт

- 1.Барилга байгууламжид судалгаа явуулж, зураг-төсвийн баримт бичгийг бэлтгэх.
- 2.Техникийн шийдэл, мэргэжлийн зөвлөмжийн дагуу өөрчилсөн төлөвлөлт хийж, орчны нутаг дэвсгэрийн барилга, байгууламжтай нийцүүлэх.
- 3.Нийтийн аж ахуй, нийгэм соёлын зориулалттай барилгын технологийн тоног төхөөрөмжийг солих, шинийг байрлуулж, тоноглох.
- 4.Барилгад чимээ шуугианы хамгаалалт, дулаалга хийх.
- 5.Барилга байгууламжийн дотор инженерийн шугам сүлжээний элэгдсэн элементүүдийг солих.

- 6.Барилгын доторхи өрөө тасалгааг засварлах.
- 7.Зураг-төслийн баримт бичигт экспертиз хийх.
- 8.Зохиогчийн хяналт хийх.
- 9.Техникийн хяналт явуулах.
- 10.Төрийн хамгаалалттай хөшөө дурсгалыг сэргээн засварлах ажил явуулах.

5.2.Их засвараар барилга байгууламжийг бүхэлд нь, эсхүл түүний хэсэг (секц, хэд хэдэн секц)-ийг засварлана. Зайлшгүй тохиолдолд барилга, байгууламжийн салангид бүрдэл хэсэг, түүнчлэн орчны тохижилтын ажлыг хийж болно.

5.3.Их засварын үед хийгдэх ажлуудаас гадна хот байгуулалтын нөхцөл ба мөрдөгдөж буй зураг төслийн нормтой зохицуулах шаардлагаар дараахь ажлуудыг нэмж гүйцэтгэж болно. Үүнд:

- Байр сууцны төлөвлөлтийн өөрчлөлт, нэмж барих давхар (давхарлаг), дотор нь барих, залгаж барих, зайлшгүй үндэслэлээр, тэдгээрийг хэсэгчлэн задлах;
- Гадна сүлжээний (төв шугам сүлжээнээс бусад) сэргээн засварлалтын ажлыг оролцуулан инженерийн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;
- Барилгын архитектурын өнгө үзэмж, түүнчлэн хаяа нийлсэн газруудын тохижилтыг сайжруулах;
- Нийтийн ба соёл ахуйн зориулалттай барилга байгууламжийн сэргээн засварлалтын ажлын үед туслах ба үйлчилгээний зориулалттай ашиглагдаж байгаа болон шинээр баригдах барилга байгууламжийг өргөтгөн тэлэх, түүнчлэн буулгасан барилгын оронд барих, барилгын цогц бүрдэлд орж байгаа, үндсэн зориулалтын барилга байгууламжуудыг барих асуудлыг тусгаж болно.

5.4.Барилга объектын сэргээн засварлалтыг төлөвлөхдөө, уг сэргээн засварлах барилгын хуучин үнэ өртөг, сэргээн засварласны дараахь өртөг зардлын үзүүлэлтийг харьцуулан тооцож, сэргээн засварлах ажлын өмнө ба хойно дүгнэлт гаргавал зохино. Сэргээн засварлалтын ажлын өртөг зардалд уг объектыг сэргээн засварласан өртгөөс гадна шинэчлэж өөрчилсөн тоног төхөөрөмжийн зардал ч багтана. Сэргээн засварлалт хийгдэж байгаа барилга байгууламжийн балансын өртгийг сэргээн засварлалт хийхэд гарсан зардал, тоног төхөөрөмжийг оролцуулан хадгалагдаж үлдсэн хэсэг /элемент/-ийн дахин тогтоосон өртөгийн нийлбэрээр тодорхойлвол зохино. Хийсэн засвар ба сэргээн засварлалтын ажлын үр дүнг барилга байгууламжийн хувийн хэрэгт тусгана.

5.5.Хот суурийн газарт хот байгуулалтын цогцолборт (орон сууцны хороолол, бичил хороолол г.м) хамрагдсан бүх барилгыг, түүний инженерийн гадна шугам сүлжээ ба зам талбайн хамт бүлгээр нь нэг мөсөн сэргээн засварлахаар төлөвлөх хэрэгтэй.

5.6.Барилга байгууламжийн сэргээн засварлалт ба их засварын өртөг нь төсөв, эсхүл тохиролцооны үнэ өртгөн дээр үндэслэгдсэн байвал зохино. Объект тус бүрийн засвар ба сэргээн засварлалтын ажлын тохиролцооны үнийг их засвар ба сэргээн засварлалт хийхэд зориулан гүйцэтгэх ажил болон бусад хүчин зүйлийн хугацаа, чанар, үр ашиг, шинжлэх ухаан техникийн түвшинг тооцон тогтоосон үнэ, тариф, норм, үнэ өртгийг харгалзан тогтоож, боловсруулсан төсөв дээр үндэслэн тодорхойлно. Төсөвт нэмэгдэл зардал, төлөвлөгөөт хуримтлал болон бусад ажлын зардлыг заавал тусгана.

5.7.Барилга байгууламжийн сэргээн засварлалт ба их засварын ажлын төсөвт өртгийн баримт бичгийг боловсруулахдаа дараахь хүчин зүйлүүдийг авч үзнэ. Үүнд:

- Техникийн үзлэг явуулах, барилгын зураг төслийг зохиохдоо физик ба моралийн элэгдлийг тодорхойлох;
- Зураг-төсвийн баримт бичгийн боловсруулахдаа зураг төслийн бүх шийдэлд зориулан төлөвлөлтийг дахин хийх, байр сууцны үндсэн зориулалтыг өөрчлөх, бүтээц, инженерийн шугам сүлжээ, эсхүл байгуулалтыг дахин өөрчлөн солих, нутаг дэвсгэрийн

тохижилт болон бусад төсөөтэй ажлуудыг авч үзэх;

- Их засвар ба сэргээн засварлалт хийх техник-эдийн засгийн үндэслэл;
- Их засвар ба сэргээн засварлалтын ажлын зохион байгуулалтын төсөл (ЗБТ) болон гэрээгээр зохицуулагдан боловсруулагдах ажил гүйцэтгэх төсөл (АГТ)-ийг боловсруулах;

5.8.Зураг-төсвийн баримт бичиг батлагдах болон барилгын засварын ажил эхлэх хоорондын хугацаа нь 2 жилээс хэтэрч болохгүй. Хуучирсан зураг төслийг орчин үеийн шаардлагад нийцсэн техникийн түвшинд хүргэх зорилгоор, захиалагчийн даалгавраар зураг төслийн байгууллага дахин холболт хийж, өөрчлөх бөгөөд шинээр сайжруулсан төслийг зохих журамд нийцүүлэн дахин баталгаажуулбал зохино.

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ИНЖЕНЕРИЙНШУГАМ СҮЛЖЭЭНИЙЗАСВАР,
ЭДЭЛГЭЭНИЙ ХУГАЦААНЫ ЖИШИГ НОРМД ХЭРЭГЛЭСЭН ГАДААД ҮГСИН
ХАДМАЛ ОРЧУУЛГА**

- 1.Богино хоолой – патрубка
- 2.Босоо хоолой – ствол
- 3.Бохир тогтоогч – грязевик
- 4.Бөглөөс цорго – пробковые краны
- 5.Бөмбөлөгөн хавхлаг – шаровойклапан
- 6.Бүрдэл хэсэг – элемент
- 7.Бүхэл чулуу – бутовые
- 8.Ваар – черепица
- 9.Гурвалсан цорго – трехходовые краны
- 10.Дицэдсэн – никелированный
- 11.Довжооны шат – крыльца
- 12.Дохиоллуур – датчик
- 13.Дулаан үүсгэвэр – калорифер
- 14.Жорлонгийн усны сав – смывные бачки
- 15.Жийрэг – сальник
- 16.Зоргодсон – фибролит
- 17.Зохистой нөхцөл – благоприятное условие
- 18.Зүймэл шал – паркетные полы
- 19.Илтавцан – лоджии
20. Могой гуурс – змеевик
- 21.Нийлэг будаг – окраска полимерными составами
- 22.Нүүрэн тал – фасад
- 23.Парапет – халхавч
- 24.Схем – бүдүүвч
- 25.Сэнсний удирдах самбар – щитовые вентилятор
- 26.Тагт – балконы
- 27.Температур ба чийгшилийн горим –температурно-влажностный режим
- 28.Тийзэн таг – штепсель
- 29.Тогооны төмөр хүрээ – короба
- 30.Төмөр гэрт хавиргат яндан халаагуур – конвектор
- 31.Цонхонцор – форточка
- 32.Ус урсгах хоолой – элеватор
- 33.Усны кран – водоразборные краны
- 34.Хаалт – задвижка
- 35.Хаалтуур – вентиль
- 36.Хавхлагт ам – клапаны
- 37.Хаг - известковое отложение
- 38.Хий хураагуур – воздухосборник
- 39.Хогны хорго – мусоросборная камера
- 40.Хөнгөн зөөвөр шат – стремянка
- 41.Хүрээ – карниз
- 42.Хэлбэржүүлсэн цементэн шал – цементные железные полы
- 43.Хэлтэй хавхлаг – колокол клапан
- 44.Хязгаарлагч төхөөрөг – дроссель шайб
- 45.Шаарган бетон – шлакобенный
- 46.Шав ба тэмдэг – маяк

47.Шавар тоосго – саманные

48.Шахлуур – гильза

49.Шүүсэн усны төхөөрөг – дренажный насос

ГАРЧИГ

Өмнөх үг	1
Нийтлэг үндэслэл	2
Барилга байгууламжийн өргөтгөл, шинэчлэл, засвар, техникийн үйлчилгээний тогтолцоо	2-10
Барилга байгууламжийн техникийн үйлчилгээ	10-15
Барилга байгууламжийн урсгал засвар	15-18
Барилга байгууламжийн их засвар ба өргөтгөл шинэчлэл	19-20
Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, эдэлгээний хугацааны жишиг нормд хэрэглэсэн гадаад үгсийн хадмал орчуулга	21